



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХУРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН, ТЭСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2021/22/СТА-ТЭЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2021 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан
үргийг тур орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын дэреадугээр газрын захирал, тэргүүлэх аудитор
Я.Самбууным
Утас: 260949 Цахим хаяг: sambuuynamya@audit.gov.mn
Аудитын менежер **Д.Энхдалай**
Утас: 261885 Цахим хаяг: enkhdaid@audit.gov.mn
Ахлах аудитор **Б.Эрдэнэзүүл**
Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Аудитор **О.Баярмаа**
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

01

ТОРИЙН АУДИТИН БАЙГУУЛАГА
ЗОРЧИЛГҮЙ
САНАЛ ДУТГИСЛЭТ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага	10
3.5.3 Урьдчилгаа	11
3.5.4 Бараа материал	11
3.5.5 Үндсэн хөрөнгө	12
3.5.6 Өр төлбөр	12
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Шилэн дансны мэдээлэл	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
3.11 Хойши хүл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчил	17
4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХТ	Барилгын хөгжлийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ГЗБГЗ3Г	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
МООНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпорац
ТӨХХК	Төрийн өмчтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨААТҮГ	Төрийн өмчтэй аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХСУХАТАУ33	Хот, суурини ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Б.МӨНХБААТАР ТАНАА

2021.04.26 № 1303

таний -ны № -т

Г Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аudit хийлээ.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аudit хийхдээз Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглувансан хангалттай бөгөөд зохиистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайландаа төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.



Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	482,518,991.0	534,480,024.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,065,770.8	37,482,525.8
33	АВЛАГА	152,708,829.8	157,907,025.5
34	УРЬДЧИЛГАА	15,387.5	14,490,898.4
35	БАРАА МАТЕРИАЛ	14,284,064.4	13,643,516.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	287,444,938.5	310,956,058.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	158,917,002.2	158,769,879.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,000.0	1,000.0
37300	Урт хугацаат зээл	1,000.0	1,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	158,916,002.2	158,768,879.2
39200	Биет хөрөнгө	90,414,865.4	90,365,106.7
39300	Биет бус хөрөнгө	67,905,482.0	67,984,509.4
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	595,654.8	419,263.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	641,435,993.2	693,249,903.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	377,408,176.3	396,880,377.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	96,968,453.0	99,885,950.5
41300	Өглөг	78,295,401.5	82,445,010.3
41400	Урьдчилж орсон орлого	18,673,051.5	17,440,940.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	280,439,723.3	296,994,426.8
42200	Урт хугацаат зээл	280,439,723.3	296,994,426.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	264,027,816.9	296,369,526.5
51	Засгийн газрын хувь оролцоо	264,027,816.9	296,369,526.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,470,083.2	2,470,083.2
51101	Өмч /терийн/ /ТӨҮГ/	8,247.3	8,247.3
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	212,479.8	212,479.8
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	73,152,925.9	73,152,925.9
51200	Хуримтлагдсан үр дүн	187,095,667.5	219,397,128.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,088,413.2	1,128,661.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	641,435,993.2	693,249,903.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	191,830,849.9	206,736,502.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,945,594.4	100,302,028.0
120	Нийтлэг татварын бус орлого	85,945,594.4	100,302,028.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,885,255.5	106,434,474.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	88,546,091.1	54,075,019.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,546,091.1	54,075,019.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,191,115.2	36,644,762.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,966,745.8	4,092,633.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	363,857.7	520,435.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,325.3	245,634.0
2104	Хангамж, бараа материалын зардал	274,461.8	514,708.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,949.1	14,339.5
2107	Томилолт, зочны зардал	150,855.7	73,341.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,183,832.6	27,843,067.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,012,087.2	3,340,604.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,354,975.9	17,430,256.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	103,284,758.8	152,661,483.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,874.2	838,362.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	151,299,746.8	57,221,197.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(48,013,113.8)	96,278,648.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	491,171,414.7	0.0	491,171,414.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(179,010,819.5)	0.0	(179,010,819.5)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,160,595.2	0.0	312,160,595.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(24,551.4)	0.0	(24,551.4)
Өмчид гарсан өөрчилөлт	(95,113.1)	0.0	(95,113.1)
Тайлант үеийн үр дүн	(48,013,113.8)	0.0	(48,013,113.8)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,027,816.9	0.0	264,027,816.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(63,977,187.4)	0.0	(63,977,187.4)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,050,629.5	0.0	200,050,629.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	40,248.2	0.0	40,248.2
Тайлант үеийн үр дүн	96,278,648.8	0.0	96,278,648.8
2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	296,369,526.5	0.0	296,369,526.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	154,123,650.3	142,639,819.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,883,095.3	36,544,540.5
120	Нийтлэг татварын бус орлого	47,883,095.3	36,544,540.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,240,555.0	106,095,279.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,585,927.0	50,426,636.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,585,927.0	50,426,636.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,794,515.8	32,350,961.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,243,692.0	7,876,923.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,855,170.6	2,179,061.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,337.4	252,422.8
2104	Хангамж, бараа материалын зардал	11,768,553.0	10,554,366.4
2105	Нормативт зардал	632.9	609.6
2106	Эд хогшил, ургал засварын зардал	17,334.2	9,934.0
2107	Томилолт, зочны зардал	177,222.0	103,524.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,457,777.2	7,777,310.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,083,796.5	3,596,808.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,791,411.2	18,075,675.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	102,537,723.3	92,213,183.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	662,738.2	476,284.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	82,382,096.6	77,878,369.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	82,382,096.6	77,878,369.6
2200	Дотоод эх үүсвэрээр	82,382,096.6	77,878,369.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(81,719,358.4)	(77,402,085.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(22,231,227.4)	(5,394,342.6)
14	Бусад эх үүсвэр	92,900,121.2	9,016,355.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000.0	5,000,000.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	110,131,348.6	9,410,697.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,412,862.5)	9,416,755.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,478,633.2	28,065,770.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,065,770.8	37,482,525.8



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	208,302,051,500.00	166,369,661,202.00	41,932,390,298.00	79.9
III. УРСГАЛ ЗАРДАЛ	24,176,245,300.00	19,551,681,191.80	4,624,564,108.20	80.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,176,245,300.00	19,551,681,191.80	4,624,564,108.20	80.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,239,661,800.00	3,171,161,850.91	68,499,949.09	97.9
Үндсэн цалин	2,351,091,400.00	2,287,790,897.00	63,300,503.00	97.3
Нэмэгдэл	778,836,300.00	774,106,511.76	4,729,788.24	99.4
Унаа хоолны хөнгөлөлт	109,734,100.00	109,264,442.15	469,657.85	99.6
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	444,213,900.00	444,213,900.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	312,595,000.00	312,595,000.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	32,904,700.00	32,904,700.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	26,323,800.00	26,323,800.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	6,580,900.00	6,580,900.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	65,809,500.00	65,809,500.00	-	100.0
Бараа үйлчилгээний ургал зардал	20,492,369,600.00	15,936,305,440.89	4,556,064,159.11	77.8
Байрны түрээс	70,578,800.00	70,454,810.00	123,990.00	99.8
Бичиг хэрэг	31,012,900.00	29,474,088.00	1,538,812.00	95.0
Тээвэр, шатахуун	26,520,600.00	26,041,700.00	478,900.00	98.2
Шуудан, холбоо, интернет төлбөр	22,899,900.00	22,899,900.00	-	100.0
Хог хаягдал зайлцуулах	199,100.00	199,100.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн зд зүйлс	19,476,800.00	18,529,658.00	947,142.00	95.1
Нормын хувцас, зөвлөн өдлэл	609,600.00	609,600.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	1,595,800.00	1,445,799.00	150,001.00	90.6
Ургал засвар	2,411,300.00	2,411,240.00	60.00	100.0
Дотоод албан томилолт	21,728,000.00	21,727,950.00	50.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг АҮТХ	1,737,642,500.00	1,610,393,867.40	127,248,632.60	92.7
Аудит, баталгаажуулалт	990,000.00	990,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	12,186,400.00	12,186,400.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	1,151,800.00	997,552.00	154,248.00	86.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	557,100.00	499,167.11	57,932.89	89.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,713,100.00	18,709,500.00	3,600.00	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх,	259,381,500.00	259,381,500.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	18,585,900.00	16,183,455.00	2,402,445.00	87.1
Терийн өмчит байгууллагад олгох татаас	4,100,000,000.00	0.00	4,100,000,000.00	0.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	14,011,655,400.00	13,689,329,084.38	322,326,315.62	97.7
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,911,100.00	1,890,000.00	21,100.00	98.9
Бусад ургал шилжүүлэг	132,562,000.00	131,951,070.00	610,930.00	99.5
IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	179,125,806,200.00	141,817,980,010.20	37,307,826,189.80	79.2
Барилга байгууламж	145,760,306,200.00	113,146,681,971.10	32,613,624,228.90	77.6
Их засвар	29,225,500,000.00	25,073,867,852.10	4,151,632,147.90	85.8
Тоног төхөөрөмж	4,140,000,000.00	3,597,430,187.00	542,569,813.00	86.9
V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ	5,000,000,000.00	5,000,000,000.00	-	100.0
Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	5,000,000,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	208,302,051,500.00	166,369,661,202.00	41,782,390,298.00	79.9
УЛСЫН ТӨССВӨӨС САНХҮҮЖИХ	208,152,051,500.00	166,219,661,202.00	41,782,390,298.00	79.9
Улсын төсвөөс санхүүжих	208,152,051,500.00	166,219,661,202.00	41,782,390,298.00	79.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	150,000,000.00	150,000,000.00	-	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000,000.00	150,000,000.00	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	164	159	5	97.0
Удирдах ажилтан	15	15	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	142	137	5	96.5
Үйлчлэх ажилтан	7	7	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл		150,494.5
ОРЛОГЫН ДҮН		3,168,439.6
Төрийн болон орон нутгийн өмчтэй бус этгээдээс авсан хандив, тусламж		606,220.9
ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		562,738.7
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,760,535.7
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		238,944.3
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		3,266,450.9
А. УРСГАЛ ЗАРДАЛ		3,083,550.9
1. Бараа үйлчилгээний зардал		2,397,988.7
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		65,460.4
Үндсэн цалин		65,460.4
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,687.8
Тэтгэврийн даатгал		3,687.8
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал		2,328,840.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		10,246.5
Дотоод албан томилолт		28,384.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,355,458.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		12,620.0
Бараа үйлчилгээний бусад зардал		922,131.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		685,562.2
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		685,562.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		182,900.0
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		182,900.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		52,483.2

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланда шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланда шалгагдагч этгээдэд барилга байгууламжийн захиалагчийн техникийн хяналтын орлого, зардлын төлөвлөлтийн талаар, харьяа зарим байгууллагын хууль эрх зүйн орчныг тодорхой болгох, он удаан жил болсон барьцааг чөлөөлөх, дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй тесөл, арга хэмжээг бүрэн дуусгаж, хөрөнгийн өмчлөлийн асуудлыг эцэслэн шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Эрдэнэзүл, аудитор О.Баярмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1199 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

БХБЯ-ны эрхэм зорилгыг “Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын ая тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

БХБЯ нь үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлж, стратегийн зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжилтийг нь хангаж ажилласан байна. Үнд:

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн, нийтийн аж ахуй, орон сууцны, инженерийн дэд бүтцийн салбаруудын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх;
- Барилгын салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлэх;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн үр дүнг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлж, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж, баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзсэн.

Тайлант онд Сангийн яам, БХБЯ-тай хамтарсан “Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний барилга, байгууламжийн захиалагчийн техникийн хяналтын үйл ажиллагааны, үр дүн”-д хийсэн дотоод аudit, санхүүгийн хяналт шалгалтаар нэр бүхий 5

аймгийн ГХБХБГ-д алдаа, зөрчлийг арилгах 14 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг дүгнэх хугацаа болоогүй байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөний дагуу Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2020 оны төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 6 зөвлөмж, “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитаар гэрээ, санхүүжилтийн талаар 3 зөвлөмж, нийт 9 зөвлөмж өгсөн байна.

3.3 Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсвийн зардал 208,302.1 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 2,083.0 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 28,065.8 сая төгрөг байснаас, эцсийн үлдэгдэл 37,482.5 сая төгрөг болж, 9,416.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.5	7.7	7.2
Банканд байгаа бэлэн мөнгө	28,065.3	37,474.8	9,409.5
Дүн	28,065.8	37,482.5	9,416.7

Эх сурвалж: БХБС-ын ЭАХБ-дын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 20,032.6 сая төгрөгийг төрийн сангийн харилцах дансанд, 17,444.6 сая төгрөгийг арилжааны банканд, 5.3 сая төгрөгийг нь бэлэн мөнгөний касст байршуулсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь Сангийн яамнаас тайлант оны эцэст БХБЯ-ны хөрөнгө оруулалтын зарим үлдэгдэл санхүүжилтийг барьцааны дансанд шилжүүлсэн, мөн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БХБЯ, ЭМЯ, БШУЯ-дын захиалгаар баригдаж байгаа барилга байгууламжид захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн, ТОСК ТӨХХК-ийн төрийн түрээсийн орон сууцанд гэрээгээр амьдарч буй иргэдтэй “Орон сууцыг түрээслээд өмчлөх гэрээ”-г байгуулсан зэргээс шалтгаалжээ.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 152,708.8 сая төгрөг байснаас, эцсийн үлдэгдэл 157,907.0 сая төгрөг болж, 5,198.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл



Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	12.2	9.6	(2.6)
Төлбөртэй үйлчилгээний авлага	931.5	806.4	(125.2)
Татаас, санхүүжилтийн авлага	10.0	673.3	663.3
Дансны авлага /ТӨҮГ/	149,352.1	154,376.6	5,024.5
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	1,835.0	841.9	(993.1)
Бусад авлага	568.0	1,199.3	631.3
Дүн	152,708.8	157,907.0	5,198.2

Эх сурвалж: БХБС-ын ЭАХБ-дын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансанд ТОСК ТӨХХК-ийн 155,672.9 сая, ГЗБГЗГ-ын 953.6 сая, ХСУХАТАҮЗЗ-ийн 658.3 сая, БХБЯ-ны 543.8 сая, бусад байгууллагын 78.4 сая, нийт 157,907.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэл өссөн нь ТОСК ТӨХХК-ийн "Шинэ яармаг төсөл"-ийг хэрэгжүүлэхээр Хөгжлийн банкнаас Юнайтэд проект групп ХХК-тай байгуулсан хөрөнгө оруулалтын дамжуулан зээлийн гэрээний дагуу олгосон 29.0 сая ам.долларын, Батлан хамгаалах яаманд хүлээлгэн өгсөн Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг худалдан авсан 9.8 сая ам.долларын зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүйгээс зээл, зээлийн хүүгийн төлбөр, валютын ханшийн зөрүүгээс, мөн "Ногоон нуур 1008 айлын орон сууцны төсөл"-ийн газар чөлөөлөлтийн төлбөрийн үлдэгдэл болон ГХБХБГ-ын 21 аймгийн 2020 оны барилга байгууламжийн захиалагчийн техникийн хяналтын орлогын үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн авлагад бүртгэсэн зэргээс шалтгаалжээ.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж төлсөн зардал дансны эхний үлдэгдэл 15.4 сая төгрөг байснаас, эцсийн үлдэгдэл 14,490.9 сая төгрөг болж, 14,475.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	15.4	14,490.9	14,475.5
Дүн	15.4	14,490.9	14,475.5

Эх сурвалж: БХБС-ын ЭАХБ-дын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал өссөн нь БНХАУ-ын Засгийн газраас олгох 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн Монголын талаас оруулах хөрөнгийн урьдчилгаа, БХТ ТӨААТҮГ-ын Интерактив ХХК-тай байгуулсан "Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сангийн цахим программыг хөгжүүлэх" ажлыг гүйцэтгэх гэрээнд заасны дагуу үе шатны ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож урьдчилж төлсөн зардалд бүртгэсэн, ХСУХАТАҮЗЗ нь сургалтын зориулалттай байр худалдан авах гэрээ байгуулан урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэнтэй тус тус холбоотой байна.

3.5.4 Бараа материал

Бараа материал дансны эхний үлдэгдэл 14,284.1 сая төгрөг байснаас, эцсийн үлдэгдэл 13,643.5 сая төгрөг болж, 640.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	277.1	337.5	60.4
Дуусаагүй үйлдвэрлэл	13,263.8	12,555.8	(708.0)
Хангамжийн материал	729.7	738.5	8.8
Бичиг хэргийн материал	133.6	68.4	(65.2)
Аж ахуйн материал	140.8	114.2	(26.6)
Түлш, шатах тослох материал	1.6	3.0	1.4

Хүнсний материал	0.2	0.3	0.1
Бусад хангамжийн материал	453.5	552.6	99.1
Мал амьтад	13.5	11.7	(1.8)
Дүн	14,284.1	13,643.5	(640.6)

Эх сурвалж: БХБС-ын ЭАХБ-дын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл буурсан нь ТОСК ТӨХХК-ийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байсан Буянт-Ухаа 2 хорооллын үйлчилгээний төвийн барилга дуусгавар болж борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө дансанд бүртгэснээс шалтгаалсан байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 158,916.0 сая төгрөг байснаас, эцсийн үлдэгдэл 158,768.9 сая төгрөг болж, 147.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	90,414.8	90,365.1	(49.7)
Барилга, байгууламж, орон сууц	77,904.8	77,160.1	(744.7)
Авто тээврийн хэрэгсэл	791.9	1,015.6	223.7
Машин тоног төхөөрөмж	1,757.7	2,103.7	346.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	338.5	455.7	117.2
Бусад үндсэн хөрөнгө	15.4	23.5	8.1
Дуусаагүй барилга, байгууламж	9,606.5	9,606.5	0.0
Биет бус хөрөнгө	67,905.5	67,984.5	79.0
Программ хангамж	114.0	210.2	96.2
Бусад биет бус хөрөнгө	67,791.5	67,774.3	(17.2)
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	595.7	419.3	(176.4)
Дүн	158,916.0	158,768.9	(147.1)

Эх сурвалж: БХБС-ын ЭАХБ-дын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал болон ТОСК ТӨХХК-ийн хойшлогдсон татварын хөрөнгөд НӨАТ-ын байгууллага хоорондын тооцооноос үүссэн авлага бүртгэлтэй байсныг аудитын явцад залруулан авлагын дансанд бүртгэсэн зэргээс шалтгаалжээ. Тайлант онд гарсан томоохон хөрөнгийн хөдөлгөөнөөс дурдвал:

- БХБЯ-нд ТӨБЗГ-ын даргын 2020 оны А-1/721, А-1/1106, А-1/1455, А-1/2230 дугаар албан бичгээр тус яамны харьяа "Ногоон нуур 1008 айлын орон сууц", "УБ хотын 7,14, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц" төслийн нэгжүүд болон Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аас нийт 265,954.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан;
- БХТ ТӨБЗГ-ын 2019 оны 525, 2020 оны 277 дугаар тогтоолоор НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй "Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ төсөл"-ийн санхүүжилтээр барьж ашиглалтад оруулсан 319.4 сая төгрөгийн Лабораторийн барилгыг хүлээн авсан;
- ГХБХБГ-т ТӨБЗГ-ын 2020 оны 169 дүгээр тогтоолоор барилга байгууламжийн захиалагчийн техникийн хяналтын орлогын эх үүсвэрээр 182.9 сая төгрөгөөр 1 ширхэг автомашин худалдан авсан.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны эхний үлдэгдэл 377,408.2 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 396,880.3 сая төгрөг болж, 19,472.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	96,968.5	99,885.9	2,917.4
Өглөг	78,295.4	82,445.0	4,149.6



Ажилчидтай холбогдсон өглөг	0.2	1.1	0.9
Бусад өглөг	78,295.2	82,443.9	4,148.7
Урьдчилж орсон орлого	18,673.1	17,440.9	(1,232.2)
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	280,439.7	296,994.4	16,554.7
Урт хугацаат зээл	280,439.7	296,994.4	16,554.7
Дүн	377,408.2	396,880.3	19,472.1

Эх сурвалж: БХБС-ын ЭАХБ-дын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өглөгийн 82,445.0 сая төгрөг, урьдчилж орсон орлогын 17,440.9 сая төгрөг тус тус эзэлж байна.

Өглөгийн үлдэгдэл өссөн нь тус яамны хөрөнгө оруулалтын зарим санхүүжилтийн үлдэгдлийг тайлант оны эцэст барьцааны өглөгийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Урьдчилж орсон орлогын үлдэгдэл буурсан нь ТОСК ТӨХХК-ийн төрийн түрээсийн орон сууцанд гэрээгээр амьдарч буй иргэдтэй “Орон сууцыг түрээслээд өмчлөх гэрээ”-г байгуулсантай холбоотой Буянт-Ухаа 2 хорооллын орон сууц, Буянт-Ухаа 1 хорооллын гаражийн борлуулалт өссөнөөс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өссөн нь ТОСК ТӨХХК-ийн Буянт-Ухаа 1, Буянт-Ухаа 2 хорооллын бүтээн байгуулалтад авсан зээлийн хүү, Шинэ яармаг хорооллын болон барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмж худалдан авахад зориулж авсан зээлийг шүүхэд шилжүүлэх хүртэлх хугацаанд хүүг тус тус хуримтлуулан тооцож өглөгт бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 264,027.8 сая төгрөг байснаас, эцсийн үлдэгдэл 296,369.5 сая төгрөг болж, 32,341.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	2,470.1	2,470.1	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	73,373.6	73,373.6	-
Хуримтлагдсан үр дүн	187,095.7	219,397.1	32,301.4
Өмнөх үеийн үр дүн	187,095.7	123,118.5	(63,977.2)
Тайлант үеийн үр дүн	-	96,278.6	96,278.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,088.4	1,128.7	40.3
Дүн	264,027.8	296,369.5	32,341.7

Эх сурвалж: БХБС-ын ЭАХБ-дын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 96,278.6 сая төгрөгийн үйл ажиллагааны үр дүнтэй ажилласан, тус яамны харьяа Ногоон нуур 1008 айлын орон сууц төслийн нэгж болон УБ хотын 7,14, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төслийн нэгжээс үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан зэрэгтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл 1,128.7 сая төгрөг болж 40.3 сая төгрөгөөр өссөн нь ТОСК ТӨХХК нь тайлант онд холбогдох байгууллагын зөвшөөрлөөр цаашид ашиглах боломжтой 104 нэрийн хөрөнгийг дахин үнэлснээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын бичилт нь БХБЯ-ны өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн, улсын комисс хүлээн авсан төсөл, арга хэмжээний 63,089.3 сая, ТОСК ТӨААТҮГ-ын татварын шалгалтын актаар болон Батбүрдэл ХХК-ийн 2016 онд барьсан барилгыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд зөрүүтэй бүртгэснийг залруулсан 668.1 сая, БХТ ТӨААТҮГ-ын өмнөх оны ногдол ашгийн төлбөр 338.7 сая, нийт 64,096.1 сая төгрөгөөр бууруулан, ТОСК ТӨААТҮГ-ын Хөгжлийн банканд төлөх хүүгийн өглөгийг зардалд бичсэнийг авлагаар бүртгэж залруулсан 118.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, зөрүү дүнгээр өмнөх үеийн үр дүнд өөрчлөлт оруулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Барилга, хот байгуулалтын яам нь тайлант онд 2,250.0 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 3,107.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 38.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 8 Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Д/д	Аймгийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Архангай	65.0	74.0	9.0	113.8
2	Баян-Өлгий	65.0	131.3	66.3	202.1
3	Баянхонгор	70.0	70.0	-	100.0
4	Булган	70.0	72.5	2.5	103.5
5	Говь-Алтай	70.0	79.4	9.4	113.4
6	Говьсүмбэр	35.0	53.3	18.3	152.4
7	Дархан-Уул	60.0	66.0	6.0	110.0
8	Дорноговь	56.6	58.3	1.7	103.1
9	Дорнод	65.0	125.5	60.5	193.1
10	Дундговь	70.0	72.3	2.3	103.3
11	Завхан	70.0	82.5	12.5	117.8
12	Орхон	65.0	79.4	14.4	122.2
13	Өвөрхангай	70.0	84.1	14.1	120.1
14	Өмнөговь	83.4	216.7	133.3	259.8
15	Сүхбаатар	65.0	65.4	0.4	100.6
16	Сэлэнгэ	70.0	94.6	24.6	135.1
17	Төв	70.0	88.4	18.4	126.3
18	Увс	70.0	198.2	128.2	283.1
19	Ховд	70.0	178.4	108.4	254.8
20	Хөвсгөл	70.0	72.9	2.9	104.1
21	Хэнтий	70.0	71.0	1.0	101.4
22	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	700.0	917.6	217.6	131.1
23	ГЗБГЗЗГ	150.0	155.3	5.3	103.5
	Дүн	2,250.0	3,107.1	857.1	138.1

Тайлант онд орлогын төлөвлөгөө 857.1 сая төгрөгөөр давсан нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт өссөнөөс барилга байгууламжийн захиалагчийн техникийн хяналтын ажил нэмэгдсэн, газар эзэмших, ашиглах, захиран зарцуулах асуудлыг цахимд шилжүүлснээр үйл ажиллагаа идэвхэжксэн зэрэгтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Тус ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 204,202.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс, төрийн өмчит байгууллагад олгох татаас 4,100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 208,302.1 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх нийт 253 хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зориулан 208,302.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 179,125.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 14,011.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэгт, 5,000.0 сая төгрөгийг дамжуулан зээлийн төлбөрт, 4,100.0 сая төгрөгийг төрийн өмчит байгууллагад олгох татааст, 6,064.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 194,140.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 14,011.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 150.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 152,530.4 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 13,689.3 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 150.0 сая, нийт 166,369.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 166,369.7 сая төгрөг буюу 79.9 хувьтай байгаа нь цар тахлын улмаас зарим төсөл хөтөлбөрийн хэрэгжилт дутуу гүйцэтгэлтэй байгаа, Харгия цэвэрлэх байгууламжийг нүүлгэн шилжүүлэхээр болсон, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг үе шатны ажлын гүйцэтгэлээр олгосон зэрэгтэй холбоотой ба тусгай зориулалтын шилжүүлгийн үлдэгдэл 322.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 213 төсөл, арга хэмжээнд 179,125.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, гүйцэтгэлээр 178 төсөл арга хэмжээнд 141,818.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 11,552.5 сая төгрөгийг барьцааны дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 1,760.5 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 606.2 сая, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 562.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 239.0 сая, нийт 3,168.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 69.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 2,328.8 сая, хөрөнгийн зардалд 182.9 сая, нийт 2,580.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 685.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан харьяа 5 байгууллагаас нийт 107.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Барилга, хот байгуулалтын сайдын 2020 онд хэрэгжүүлэх төсөв, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 86 зорилтын 253 арга хэмжээг нийт 95.2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн ба 4 арга хэмжээний гүйцэтгэл зорилтолт түвшинд хүрээгүй байна. Тухайлбал:

1. “Барилга байгууламжийн эзлэхүүн, барилга байгууламж барих эдэлбэр газрын талбайн харьцааг тодорхойлох аргачлал”-ын төслийг боловсруулах;
2. Барилга байгууламжийг хүчинтгэх эрх зүйн орчныг бүрдүүлж улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж хүчинтгэх ажлыг эхлүүлэх;
3. “Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн сан”-г бүрдүүлэх болон барилгын салбарын ажиллах хүчиний эрэлт /2020, 2021/-ийг тодорхойлох судалгааны ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
4. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой бусад салбарын норм, нормативын баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд төсөв захирагч мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд ТЕЗ-ийн мэдээлбэл зохих 108 мэдээллээс 92 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 147.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 804.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 912.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 27 зөвлөмжийг хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	2	147.8	2	147.8	-	-	100.0
Албан шаардлага	2	804.1	2	804.1	-	-	100.0
Зөвлөмж	27	912.2	24	912.2	3	-	83.6
Нийт дүн	31	1,864.1	28	1,864.1	3	-	94.5

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зарим зөвлөмжийн биелэгдээгүй шалтгааныг тодруулж, авсан арга хэмжээний талаар дурдвал:

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлд “Үйл ажиллагааны төсөвт тусгагдсан 2 байгууллагын гишүүнчлэлийн хураамжийн зардал 3.8 сая төгрөгийг бүртгэж, тайлагнаагүй алдааг залруулах”-аар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй тул албан шаардлага өгсөн.
- ТОСК ТӨХХК-д “Орон сууцны санхүүжилтийн корпорац ХХК-аас шилжүүлэн бүртгэсэн 16 харилцагчийн 1,221.5 сая төгрөгийн авлага, 8 харилцагчийн 167.2 сая төгрөгийн өглөгийн тодорхой бус үлдэгдлийг дахин нягталж үр дүнг шийдвэрлэх” зөвлөмжийн дагуу Ерөнхий захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулан 16 харилцагчийн залруулгыг хийсэн ба холбогдох баримтыг бүрдүүлж авлага, өглөгийг барагдуулахаар ажиллаж байна.
- ГЗБГЗЗГ нь “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж тайлагнадаг боловч ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаар нэгтгэж устгах бичилт хийдэг асуудлыг шийдвэрлэх”-ээр өгсөн зөвлөмжийн дагуу Сангийн яамны Төсвийн бодлогын газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна.

3.11 Хойшхи үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц, дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай асуудал илрээгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" 4, "Хязгаарлалттай" 1 /TOCK ТӨХХК/ дүгнэлт өгсөн байна.

4.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 9,653.5 сая төгрөгийн 30 алдаа, зөрчлийг илрүүлснээс 9,317.8 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 181.1 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 154.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 17 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 234.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 234.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 3 алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

БХБЯ-ны хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд бүртгэлтэй 5-аас дээш жилийн насхилттай 23 аж ахуйн нэгж байгууллагын холбогдох баримтын бүрдэл дутуу, хуримтлагдсан 234.4 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлевлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үнд:

1. Барилга байгууламжийн захиалагчийн техникийн хяналтын орлого, зардлын төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тус яамны харьяа зарим байгууллагууд нь барилга байгууламжийн захиалагчийн техникийн хяналтын орлого, зардлыг төлөвлөхгүйгээр нэмэлт санхүүжилтийн "Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого" дансанд хүлээн авч зарцуулсан нь холбогдох хууль журамд нийцэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар баталсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмын 1.3.2-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид барилга байгууламжийн захиалагчийн техникийн хяналтын орлогыг бүрдүүлэх, зарцуулах талаар журам гаргах, эсвэл техникийн хяналтын орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж, зардлыг тусгах, мөн нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулахгүй байх;

2. Дуусаагүй барилга байгууламжид бүртгэлтэй хөрөнгийн өмчлөлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Хөгжлийн банкны санхүүжилтээр 2014-2017 онд "Дэд бүтэц төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлсэн дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй 9,606.5 сая төгрөгийн өртөг бүхий 3 төсөл арга хэмжээг бүрэн дуусгаж хөрөнгийн өмчлөлийн асуудлыг эцэслэн шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.4, 4.5-д заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид санхүүжилтийг бүрэн олгосон барилга байгууламжийг улсын комисс хүлээн авах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авах;

3. Хууль, эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Тус яамны харьяа ГЗБГЗЗГ-ыг Засгийн газрын 2014 оны 128 дугаар тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагч байхаар тогтоож, 21 аймгийн ГХБХБГ болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны төсвийг төлөвлөж батлуулан, санхүүгийн тайланг нэгтгэн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэдэг боловч ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд устгах бичилт хийдэг, санхүүжилтийг орон нутгийн ТЕЗ-даар дамжуулан Тусгай зориулалтын шилжүүлгээр олгож байгаа нь холбогдох хууль тогтоомжийн заалтууд хоорондоо зөрчилдөх, зохицуулж буй эрх зүйн орчин ойлгомжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Засгийн газрын 2014 оны 128 дугаар тогтоолоор ГЗБГЗЗГ-ыг Төсвийн төвлөрүүлэн захирагч байхаар тогтоосон боловч уг тогтоол нь Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд "Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх", 61.1.5-д "Газрын харилцаа, кадастр" гэсэн заалтууд хоорондоо зөрчилдөх байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Мөрдөж буй хууль, тогтоомжийн заалтууд хоорондоо зөрчилдөх, зохицуулж буй эрх зүйн орчин ойлгомжгүй асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл


/сая төгрөг/

№	Харьяа байгууллагууд	Дүгнэлтийн хэлбэр			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таталсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Төсвийн ерөнхийлөн захирагч										
1	Барилга, хот байгуулалтын сайд	1						2		-
	Дүн	1						2		-
Төсвийн төвлөрүүлэн захирагч										
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	1				1		50.9	3	96.1
	Дүн	1				1		50.9	3	96.1
Төрийн өмчтэй үйлдвэрийн газар										
1	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ	1				1		66.0	3	48.6
2	ТОСК ТӨХХК		1			2		15.4	7	-
	Дүн	1	1			3		81.4	10	48.6
Зохицуулах зөвлөл										
1	Хот, сууринь ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл	1				2		-	2	3.5
	Дүн	1				2		-	2	3.5
Төсвийн шууд захирагч										
1	Барилга, хот байгуулалтын яам	1				1		48.8	2	6.4
2	БХБЯ-ны хөрөнгө оруулалт, их засвар					1		234.4	1	-
	Дүн	1				2		283.2	3	6.4
Төсөл хөтөлбөр										
1	Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ төсөл									
2	Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл									
3	Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захирагааны төсөл									
	Дүн	5	1	-	-	-	-	8	415.5	20
	Нийт дүн									154.6

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

/сая төгрөг/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулла-гаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	БХБЯ-ны хөрөнгө оруулалт, их засвар: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд бүртгэлтэй 5-аас дээш жилийн насхилттай 23 аж ахуйн нэгж байгууллагын холбогдох баримтын бүрдэл дутуу, хуримтлагдсан 234.4 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангартгүй байна.	234.4	Албан шаардлага өгөх	ТНБД, СХОГ-ын дарга, СТСХ-ийн дарга	С.Магнайсүрэн, Э.Ганхүү С.Должинсүрэн
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар: Сэлэнгэ аймгийн ГХБХБГ нь техникин хяналтын орлогогос холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй 50.9 сая төгрөгийн 1 ширхэг автомашиныг худалдан авсан байна.	50.9	Албан шаардлага өгөх	Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын дарга	Б.Саруултөгс
3	Барилга, хот байгуулалтын яам: Тайлант онд төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгоходоо холбогдох журамд заасан хувиас хэтрүүлэн нийт 48.8 сая төгрөгийг илүү олгосон байна.	48.8	Албан шаардлага өгөх	ТНБД, ахлах нягтлан бодогч	С.Магнайсүрэн П.Дэлгэрмаа
4	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ: Тайлант онд нэр бүхий 19 хэвлэл, мэдээллийн байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээг 6-12 сарын хугацаатай байгуулсан боловч гэрээнд гарын үсэг зурж санхүүжилтийг бүрэн олгохоор засны дагуу ажил эхлээгүй байхад гэрээ дүгнэсэн актүй, 66.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.	66.0	Албан шаардлага өгөх	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Амарсанаа Г.Гантуул
5	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл: 1. Өмнөх аудитаар өгсөн "Гишүүнчлэлийн хураамжийн зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнах" зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. 2. Шилэн дансанд 7 мэдээллийг хугацаандаа оруулаагүй байна.	-	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Ж.Батсуурь Д.Сэлэнгэ
6	Төрийн орон сууцны корпораци ТӨХХК: 1. УАГ-аас 2017 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу Б.Энхзулаар нөхөн төлүүлэх 15.4 сая төгрөгийн үлдэгдлийг төлүүлээгүй, 2. Шилэн дансанд 25 мэдээллийг хугацаандаа оруулаагүй байна.	15.4	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч	Л.Батжаргал С.Ереөлт
Нийт дүн		415.5			





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 554/0010001
согт 2021/20/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцааны өглөгийн дансанд бүртгэлтэй 5-аас дээш жилийн насхилттай, 23 аж ахуйн нэгж байгууллагын холбогдох баримтын бурдэл дутуу, хуримтлагдсан 234.4 сая төгрөгийн барьцааг чөлөөлөх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлэсгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Дээрх аж ахуйн нэгж байгууллагуудын барьцааг холбогдох хуульд нийцүүлэн чөлөөлөх арга хэмжээг авч албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор гаргаж Үндэсний Аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн нарийн бичгийн дарга С.Магнаисурэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.2021 Bichig Kheres Albanshaardлага 2021-09-26auditor 2-R Gazar i Docx

001081189